

LET'S DO THIS – Mongolian

5-11 насны хүүхдүүдэд зориулсан COVID-19-н эсрэг дархлаажуулалт

Одоо
ЗАХИАЛГА
АВЧ БАЙНА

5-11 насны хүүхдүүд COVID-19 халдварын эсрэг дархлаажуулалтанд яагаад хамрагдах ёстой вэ?

COVID-19 нь хүний биед ноцтой эмгэг үүсгэх, нас баралтанд хүргэх, мөн урт хугацаагаар эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх аюултай вирус юм. Энэ нь хүнээс хүнд халдахдаа маш хурдан бөгөөд заримдаа шинж тэмдэг багатай эсвэл ямар ч шинж тэмдэг илрэхгүй байдаг тул тухайн хүн бусдыг халдварлуулахаас өмнө өөрийнхөө халдвар авсан эсэхийг мэдэхэд бэрхшээлтэй болгодог.

Хэдийгээр COVID-19-н халдвар хүүхдэд насанд хүрэгчидтэй харьцуулахад хөнгөн илэрдэг ч хүүхдүүдийг дархлаажуулалтанд хамруулах хэд хэдэн ноцтой шалтгаан бий. Үүнд:

- Вакцин бол дархлалын системд дэмжлэг үзүүлж байдаг. Та хүүхдээ дархлаажуулалтанд хамруулснаар тэднийг COVID-19-р хүндээр өвдөх болон түүний урт хугацаанд гарах аливаа үр дагавраас хамгаалж байгаа хэрэг юм.
- Дархлаажуулалт нь мөн халдварын тархалтыг багасгаж, гэр бүл, найз нөхөд болон хамт олны хүрээлэл дэх бүх насны эмзэг, өртөмтгий хүмүүсийг хамгаалахад тусална.
- Дархлаажуулалт нь хүүхдүүдийг сургуульдаа үргэлжлүүлэн явах болон сурч боловсроход нь чухал аливаа нийгмийн арга хэмжээнүүдэд хамрагдах боломжийг бүрдүүлнэ.

Дэлхий даяар сая сая хүүхдүүд аль хэдийнээ COVID-19 халдварын эсрэг дархлаажуулалтанд аюулгүй хамрагдсан байна. Судалгаагаар дархлаажуулалт нь COVID-19 халдварын ноцтой эмгэгээс хүүхдүүдийг сайтар хамгаалахаас гадна таны гэр бүл аюулгүй, сайн сайхан байхад туслах боломжтой гэж тодорхойлсон болно.

Хүүхдүүд насанд хүрэгчидтэй адил тунгаар ижил вакцин хийлгэх үү?

Үгүй. 5-11 насны хүүхдэд зориулсан зөвшөөрөгдсөн вакцин нь тусгай Pfizer (Comirnaty) хүүхдийн вакцин байх ба 8 долоо хоногийн зайтай 2 тун хийгдэх болно.

5-11 насны хүүхдэд зориулсан Pfizer вакцины тун нь 12 болон түүнээс дээш настай хүмүүст хийгдсэн тунгийн ойролцоогоор гуравны нэгтэй тэнцэнэ. Энэ насны бүлэгт зориулсан бага тун нь 12 болон түүнээс дээш насны хүмүүст хийгдсэн тунтай адил хүүхдэд өндөр түвшний хамгаалалт үзүүлэх чадвартай юм.

Хүүхдэд илрэх хариу урвал нь насанд хүрэгчидтэй адил байх уу?

Тийм. COVID-19-н вакцин хийлгэсний дараа хүүхдэд насанд хүрэгчидтэй адил нийтлэг хариу урвалууд илрэх боломжтой.

Эдгээр хариу урвалууд нь ихэнхдээ хөнгөн бөгөөд нэг эсвэл хоёр өдрийн дараа алга болдог. Үүнд:

- Толгой өвдөх
- Халуурах болон жихүүдэх
- Ядрах / сульдах
- Булчингаар өвдөх болон гарын тарьсан хэсэгт хөндүүрлэх

Хөнгөн хариу урвалууд нь хэвийн бөгөөд энэ нь таны дархлалын систем тухайн вакцинд хариу үзүүлж байгаа хэрэг юм. Вакцины дараа хүнд ноцтой хариу урвал илрэх нь маш ховор бөгөөд харин COVID-19-н халдвар авсны дараа биед илрэх эдгээр ноцтой хариу урвалуудын эрсдэл маш өндөр юм. Хэрвээ хариу урвалууд удаан үргэлжлэх эсвэл танд санаа зовнисон зүйл байвал GP буюу өрхийн эмчдээ хандаарай.

Ноцтой хариу урвал илрэх эрсдэл байна гэдэг нь би хүүхдээ дархлаажуулалтанд хамруулах хэрэггүй гэж ойлгох уу?

Үгүй. Австрали улсад ашиглаж буй COVID-19-н бүх вакцинууд нь аюулгүй байдлын өндөр үзүүлэлттэй ба ашиглах зөвлөмж болон зөвшөөрлөө авахаасаа өмнө Эм, Эмийн Бүтээгдэхүүнийг Хянах Газар (TGA) болон Австралийн Дархлаажуулалтын Техникийн Зөвлөх Баг (ATAGI) дахин дахин туршилт хийж, үнэлгээ хийлгэсэн байдаг.

Одоогийн байдлаар АНУ-д 5 сая гаруй хүүхдүүд мөн дэлхий даяар 5-11 насны түүнээс олон сая хүүхдүүд COVID-19-н вакциныг аюулгүйгээр хийлгэсэн байна.

COVID-19 -н дархлаажуулалт миний хүүхдийн өсөлт, хөгжил эсвэл ирээдүйн нөхөн үржихүйн чадварт нөлөөлөх үү?

Үгүй. COVID-19-н вакцин хүүхдийн өсөлт, хөгжилд нөлөө үзүүлдэг гэсэн ямар ч нотолгоо байхгүй.

COVID-19 халдварын урт хугацааны нөлөөлөл нь хүний эрүүл мэнд, сайн сайхан байдалд удаан хугацаанд нөлөөлнө. Уг вирусын халдвар авснаас гарах хүндрэл нь дархлаажуулалтын дараа илрэх хөнгөн хариу урвалаас илүү эрсдэл өндөртэй юм.

Хэрвээ миний хүүхэд COVID-19-н халдвар аль хэдийн авчихсан бол дархлаажуулалтанд хамрагдах хэрэгтэй юу?

Тийм. COVID-19-н халдвар авсан хүүхдүүд бүрэн эдгэрсний дараа дархлаажуулалтанд хамрагдах хэрэгтэй ба энэ нь дахин халдвар авахаас сэргийлэхэд тусална.

Миний зөвшөөрөлгүйгээр миний хүүхэд дархлаажуулалтанд хамрагдах боломжтой юу?

Үгүй. 5-11 насны хүүхдүүд COVID-19-н вакцин хийлгэхийн тулд эцэг эх эсвэл асран хамгаалагч нь зөвшөөрөл олгосон байх ёстой.

Вакцин хийлгэхээр цаг товлох үед, мөн вакцин хийлгэх үед уг зөвшөөрлийг эцэг эх, асран хамгаалагч өгсөн байх шаардлагатай. Хэрвээ эцэг эх, асран хамгаалагч нь вакцин хийлгэх үед хүүхэдтэйгээ хамт ирэх боломжгүй бол цаг товлох зөвшөөрлийн хуудсыг онлайн аргаар бөглөх үедээ вакцин хийлгэх өдөр хүүхэдтэй хамт ирэх насанд хүрсэн өөр хүнийг томилох боломжтой.

Цаг товлох үедээ төлөөлөн ирэх насанд хүрсэн хүний мэдээллийг заавал өгөх ба ингэснээр вакцин хийлгэх өдөр уг итгэмжлэгдсэн төлөөлөгчийн зөвшөөрөл олгох эрх болон хувийн бичиг баримтыг шалган оруулахад хэрэг болно.

Зөвшөөрлийн тухай дэлгэрэнгүй мэдээллийг [Vaccination consent FAQs for parents and guardians \(Эцэг эх болон асран хамгаалагчдад зориулсан дархлаажуулалтын зөвшөөрлийн тухай FAQ буюу түгээмэл асуултууд\)](#) холбоосоор орж авна уу.

Хүүхдүүд COVID-19-н дархлаажуулалтанд заавал хамрагдсан байх ёстой юу? (сургуульд явах болон спортын арга хэмжээнд оролцох гэх мэт)

Үгүй. COVID-19-н эсрэг дархлаажуулалтанд заавал хамрагдах албагүй ч хамрагдахыг чухалчлан зөвлөж байна.

Хүүхдүүд сургуульд явах эсвэл олон нийтийн спортын арга хэмжээнд оролцоход COVID-19-н вакцин хийлгэсэн байх шаардлага тавигдахгүй.

Миний хүүхэд хүч нэмэгдүүлэгч (booster) 3 дах тун хийлгэж болох уу?

Үгүй. Залуу хүмүүст анхдагч дархлаажуулалт нь хангалттай дархлаа тогтоодог.

Ирээдүйд энэ насны бүлэгт хүч нэмэгдүүлэгч (booster) тун хийх хэрэгтэй эсэхийг ATAGI буюу Австралийн Дархлаажуулалтын Техникийн Зөвлөх Баг судалж үзэх болно.

Хүүхдүүд COVID-19-н дархлаажуулалтанд сургууль дээрээ хамрагдах уу?

Үгүй. Та хүүхдээ COVID-19-н дархлаажуулалтанд хамруулахдаа GP буюу өрхийн эмч, харьяа эмийн сан, Уугуул Нийгмийн Бүлгийн Хяналтын Эрүүл Мэндийн Үйлчилгээ эсвэл NSW Health дархлаажуулалтын клиникээр дамжуулан цаг товлоно уу.

Хэрхэн цаг товлох вэ?

Эцэг эхчүүд аль болох хурдан хүүхдээ дархлаажуулалтанд хамруулах цаг товлохыг зөвлөж байна.

Онлайн аргаар одоо цаг товлоно уу - www.nsw.gov.au/covid-19/vaccination/get-vaccinated

Утсаар залган цаг товлох: Цаг товлох шугам: 1800 57 11 55 / Орчуулгын Үйлчилгээ (TIS): 131 450